



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 04

Сүхбаатар сум

Хоршоог хөгжүүлэх сангийн
2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн
гүйцэтгэлийн аудитын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн 17 сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын хяналт шалгалтын дүнг хорооны хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:


Нэг. Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дотоод аудитын хорооны дарга (аймгийн Засаг дарга)-ын 17 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын үр дүнгээр “Их” эрсдэлтэйд тооцож, “Хангалтгүй” гэсэн дүгнэлтийг баталсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолыг аудитын тайлан, санхүүгийн хяналт шалгалтын танилцуулга, ажлын баримтуудын хамт холбогдох албан тушаалтанд хүргүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг даалгасугай.

Хорооны дарга:  Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:  Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:  Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

4324009004



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)